

“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 09 дүгээр сарын
11-ний өдөр

№ 01

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2021 оны 9 дүгээр сарын 11-ны өдрийн 17 цаг 00 минутад Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, “MN tower” 12 дугаар давхарт 1204 тоот өрөөнд эхэллээ.

Гүйцэтгэх захирал Н.Алтансүх: “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн нийт хувьцаа эзэмшигчид та бүхэндээ энэ өдрийн мэндийг өргөн дэвшүүлж хуралдаа идэвхитэй оролцож байгаа явдалд хурлыг зохион байгуулж байгаа ажлын албаныхаа нэрийн өмнөөс талархал дэвшүүлье. Хурал зохион байгуулах комисс байгуулагдсан байгаа. Комисст компанийн ажлын алба ажиллаж байгаа. Мөн тооллогын комиссын бүрэлдэхүүнийг томилсон байгаа. Даргаар “Монсек ҮЦК” ХХК-ийн захирал М.Отгонбаатар, гишүүдээр Б.Отгонцацрал, Ш.Нарангаравуу нар ажиллаж байна. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын даргаар ТУЗ-ийн дарга Ж.Жаргалсайхан, тэргүүлэгчээр ТУЗ-ийн гишүүн Ч.Андсайхан нарыг томилсон тогтоол гарсан. За ингээд Жаргалсайхан, Андсайхан нарыг суудлаа эзлэхийг урьж байна.

Хурлын дарга Ж.Жаргалсайхан: хувьцаа эзэмшигчид та бүхэндээ энэ өдрийн мэндийг дэвшүүлж хуралдаа идэвхитэй оролцож байгаад талархал дэвшүүлье. Энэ удаагийн хурлаар ТУЗ-ийн сонгууль явагдаж байгаагаараа онцлог байгаа. 4 сард хурал болоогүй шалтгаан нь ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшсэн хүмүүс маань өөрийн биеэр оролцох ёстой. Энэ үед цар тахлын улмаас бид хөл хорионд орсон байсан учраас хурал хойшилсон байгаа шүү. За ингээд тооллогын комисс ирцээ танилцуулаад хурлаа эхлэх үү.

Тооллогын комиссын дарга М.Отгонбаатар хурлын ирц болон хурлыг хүчин төгөлдөрт тооцох тухай тогтоолыг уншиж танилцуулав.

Хурлын дарга Ж.Жаргалсайхан хурлыг нээв. Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигч та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилье. Тооллогын комиссын тогтоол гарлаа. Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц бүрдсэн учраас энэхүү хурлыг нээснийг мэдэгдээд хурлаар хэлэлцэх асуудлаа танилцуулъя гээд хурлаар хэлэлцэх асуудал болон хурлын дэгийг уншиж танилцуулав.

Хурлын дарга Ж.Жаргалсайхан: Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх илтгэлээ тавина уу хэмээн Гүйцэтгэх захирал Алтансүхийг урьж байна.

Гүйцэтгэх захирал Н.Алтансүх: Илтгэлийн өмнө шинэ гишүүд, анх удаа хуралд оролцож байгаа хүмүүс байгаа учраас ирцтэй холбоотой товчхон тайлбар хэлье. Сүүлийн 2 жилийн хугацаанд СЦХ-оос хувьцаа эзэмшигчдийн хуралд урьдчилсан байдлаар санал өгч болдог, утсаар санал өгч болдог, төлөөлүүлж санал өгч болдог зарим хэсэг нь танхимаар гээд хосолсон аргаар хурал хуралдуулж болох журмууд гарсан. Энэ удаа ТУЗ-ийн сонгуультай байгаа учраас яг саналын хуудсаар санал өгч заавал төлөөлөл байлгаж танхимаар хуралдах шаардлага үүссэн учир компани албан бичгээр санхүүгийн зохицуулах хороо, хөрөнгийн биржид мэдэгдээд хурлыг хойшлуулж өнөөдөр хийж байгаа. 9-нд эцсийн байдлаар ТУЗ-ийн сонгогдох бүрэлдэхүүн бүрдэж гарсан учраас 2 хоногийн өмнөөс эхлээд хүмүүс утсаар, онлайнаар санал өгөөд явсан. Тэр тоогоороо 51 хүн 53 хувь болж хурлын ирц гарч байгаа шүү гэдгийг тайлбарлачихъя гэж бодож байна. За илтгэл бол 4 сард компанийн пэйж

хуудсан дээр тавигдсан. Тэр 4 сарынхаа тоо баримтан дээр өнөөдрийг хүртэлх тоо баримтыг шинэчилж оруулаад бүрэн эхээр нь уншиж сонсоё гэж бодож байнаа гээд тайланг уншиж сонордуулав.

Хурлын дарга Ж.Жаргалсайхан: Алтансүх захиралд баярлалаа. Тайлан илтгэлтэй холбоотойгоор ТУЗ бол гүйцэтгэх захиралын тайлант жилийн хугацааны үйл ажиллагааг дүгнээд гүйцэтгэх захирал болон гүйцэтгэх удирдлагын багийн үйл ажиллагааг хангалттай гэж дүгнэсэн дүгнэлт байгаа. Үүнтэй холбоотойгоор хурлаас 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн тухай тогтоол гарах ёстой. Тайлантай холбоотой асуудлаар асуулт байна уу?

Хувьцаа эзэмшигч: Компанитай хамтарч ажиллаж байгаа “Шинэ зуун зөвлөлдөх зөвлөл” ТББ-ын гүйцэтгэх захирал, хувьцаа эзэмшигч Сарантуул гэж хүн байна. Багш нарын асуудлаар нилээд тууштай явах хүмүүнлэг, хүнлэг чанартай төсөл байна гээд хамтарч ажиллах саналыг хүлээж аваад хамтран ажиллаж байна. За ингээд нэг асуулт байна. Багш, эмч, гэрлийн өргөө гээд яг хэдэн хүмүүс байна. Эднээс мөнгө татаж төвлөрүүлдэг данс нь нэг байдаг уу, тус тусдаа данстай юу гэж асууя. 2-рт үйл ажиллагааны маань явц бүтэн жил гаран боллоо хувьцаат компани маань хөрөнгө оруулалтаа ямар байдлаар шийдэх гэж байна вэ. Үүн дээр хариулт сонсмоор байна.

Гүйцэтгэх захирал Н.Алтансүх: 5 бүлэг бүтэцтэй ажиллаж байна. Тэрний том төлөөлөл манай багш нарын бүлэг байгаа. Багш нарын сүүлийн тоо бол 690 багш “хувьцаат орон сууц төсөл”-д оролцож байна. Нийт 800 гаран багш байснаас буцаалт гэж нийгмийн амьдралтай холбоотой асуудлууд гарсан. Дээрээс нь эмч нар, хуулийн салбарынхан, ТББ-уудын 2 бүлэг байна. Төсөлд оролцож байгаа нийт хүмүүс маань компанийн нэг дансаар л харьцаж байгаа. 2 дах асуудал хөрөнгө оруулалтан дээр маш идэвхитэй ажиллаж байна. 100 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтан дээр ажиллаж байна. Хугацаа нь нилээн дөхчихсөн байгаа. Хөрөнгө оруулалт ороод ирэхээр дуусаагүй барилга руу хөрөнгө оруулна гэдэг асуудлыг зогсоосон. Болохгүй бүтэхгүй гэдгийг нь бид 8 компани, 320 орон сууцан дээр туршаад үзчихсэн. Одоо зөвхөн бэлэн мөнгөний ордертой барилгыг худалдан авах журамруу шилжиж байгаа. Тийм учраас гардуулалтууд ихсэх байх. Хөрөнгө оруулалт ороод ирэхээр бүртгэгдсэн байгаа 1300 хүний орон сууцны асуудлыг түлхүүр гардуулах хэмжээнд эс чадвал маш ойрхон хугацааны захиалгын хэмжээнд зохион байгуулж болноо гэж төлөвлөж байна.

Хувьцаа эзэмшигч: Отгонбаатар захиралаас асуух зүйл байна. Бондын худалдан авалтын мөнгө бондын дансруу орж байгаа. Зарим нь хувьцаат компанийн дансруу хийчихсэн асуудал байгаа үүнийг цэгцэлж чадсан уу? Хувьцаа захиалсан бүх багш нарын данс нээгдсэн үү?

Монсек ҮЦК захирал Отгонбаатар: “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК, Мосек ҮЦК хоёрын хамтын ажиллагааны гэрээ бол стратегийн дагуу тодорхой хэмжээний бондыг гаргахаар гэрээлсэн. Гэхдээ энэ бонд маань онцгой нөхцөлтэйгээр анхнаасаа компанийн удирдлагаас хүсэлт тавьсан. Гаднах санхүүжилт босгох гэхээсээ илүү яг энэ хөтөлбөрт орж байгаа хувьцаа эзэмшигч багш нарынхаа оролцоог түлхүү анхааръя аа гэдэг үүднээсээ багш нарынхаа оролцоог хангахыг хичээж явсан шүү. Түүнээс бол тодорхой хэмжээний санхүүжилт хийе гэсэн хөрөнгө оруулагч байсан. 2-рт бондын төлбөрийг гүйцэтгэх захирал Алтансүх, Монсек 2 тулгаад явж байгаа. Тэрэн дээр санаа зовох зүйл байхгүй. Хэн гэдэг хувьцаа эзэмшигч, хэн гэдэг бонд эзэмшигч хэдэн төгрөг шилжүүлсэн хэдэн хувийн хүү бодолттой байгаа, ямар шатандаа байгаа гэдэг бүх зүйлийг хийгээд явж байгаа. За тэр багш нарын данс нээх асуудал дээр нэг тайлбар хэлье. Монсек ҮЦК дээр багш нар маань данс нээлгэх хүсэлтээ өгсөн. Үнэт цаасны данс нь бол нээгдчихсэн. Хамгийн чухал нь шинэ систем нэвтэрсэнтэй холбоотойгоор клерингийн банк гэдэг хамтрагч болох хаан банкин дээр

арилжаа дундын эскроу данс нээх шаардлага байдаг. Энэ нөхцөл байдал нь манайх их ачаалалтай сайн ажилласан гэдэг үүднээсээ хаан банкнид системийн гажуудал үүсээд нэг аж ахуйн нэгж дээр эскроу данс нээх харилцагчдын тоо чинь манай лимитээс хэтэрчихлээ. Бид системийн гажуудлыг засахын тулд тодорхой цаг хугацаа хэрэгтэй байнаа гэдэг албан тоот өгчихсөн байна. Үүнээс шалтгаалаад зарим багш нарын эскроу данс нээх үйл ажиллагаа буюу арилжаанд орох боломжгүй болсон тул бусад брокерийн компаниуд дээр үйлчлүүлээч гэдгийг компанийн менежерт хэлчихсэн байгаа. Үүнийг зохицуулаад явж болно.

Хурлын дарга Ж.Жаргалсайхан: за өөр асуулт байна уу?

Хувьцаа эзэмшигчид: Байхгүй

Хурлын дарга Ж.Жаргалсайхан: Асуулт байхгүй бол 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн хурлаар дүгнэсэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тогтоолын төслийг уншиж танилцуулъя. /уншиж танилцуулав/ Тогтоолын төсөлд оруулах санал байна уу.

Хувьцаа эзэмшигчид: Байхгүй

Хурлын дарга Ж.Жаргалсайхан: за тэгвэл тогтоолын төслийг батлах уу?

Хувьцаа эзэмшигчид: Баталъя.

Хурлын дарга Ж.Жаргалсайхан: за 2-р асуудал ногдол ашиг хуваарилахгүй тухай. “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн ТУЗ-өөс 2021 онд ногдол ашиг хуваарилахгүй гэсэн шийдвэр гарсан. Компани ашиг байхгүй санхүүгийн тайлан баланс дээр ашиг байхгүй орлого, зарлага гэж явж байгаа Алтансүх захиралын тайлан дээр тодорхой яригдсан. Тийм учраас тогтоолын төслөө батлах уу?

Хувьцаа эзэмшигчид: Баталъя.

Хурлын дарга Ж.Жаргалсайхан: Дараагийн асуудал нэмэлт хувьцаа гаргах тухай. “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК нь 1 5205 600 \нэг тэрбум таван сая хоёр зуун таван мянга зургаан зуу\ ширхэг зарласан хувьцаатай гэж дүрмэндээ байдаг үүнээс гаргасан хувьцаа нь 5 205 600 \таван сая хоёр зуун таван мянга зургаан зуу\ нэг тэрбум нь зарлачихсан байгаа хувьцаа. Энэ зарласан байгаа хувьцаанаас бид хэрэгжүүлж буй төслүүдээсээ хамаараад 300 000 000 \гурван зуун сая\ ширхэг хувьцааг давуу эрхийн хувьцаагаар гаргая гэсэн шийдвэртэй байгаа. Давуу эрхийн хувьцааг та нар мэдэж байгаа компани ашигтай ажилласан уу үгүй юу гэдгээс үл хамаараад ногдол ашиг бичигдээд өр болоод явж байдаг ийм хувьцааг хэлж байгаан. Мөн 30 000 000 \учин сая\ ширхэг энгийн хувьцаа гаргая гэдэг асуудал гарч ирж байгаа. Хэрхэн яаж гаргах вэ гэдгийг ТУЗ шийддэг. Үүнтэй холбоотойгоор дүрмэнд өөрчлөлтүүдийг оруулна.

Хурлын дарга Ж.Жаргалсайхан: за 3-р асуудал дээр асуух асуулт байна уу.

Хувьцаа эзэмшигчид: Байхгүй

Хурлын дарга Ж.Жаргалсайхан: тогтоолын төслийг уншиж танилцуулав. Тогтоолын төсөлтэй холбоотой асуулт, санал байна уу?

Хувьцаа эзэмшигч: Нэмж гаргах хувьцаанаасаа одоо байгаа хувьцаа эзэмшигчиддээ ямар боломж олгох вэ?

Хурлын дарга Ж.Жаргалсайхан: Нэмэлт хувьцаа гаргасан нөхцөлд таны хувийг багасгахгүйн тулд танд санал болгоно. Өөрөөр хэлбэл арилжаанд оролцоод нэмэгдсэн үнээр биш одоо гаргаж байгаа нэрлэсэн үнээр авах боломжтой. Авах давуу эрх нь танд байгаа.

Хурлын дарга Ж.Жаргалсайхан: за өөр асуулт байхгүй бол тогтоолын төслөө батлах уу?

Хувьцаа эзэмшигчид: Баталъя.

Хурлын дарга Ж.Жаргалсайхан: за 4-р асуудал компанийн стратегийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл. Энэ асуудлын талаар товчхон мэдээлэл хийе. Стратегийн асуудлын хувьд өнөөдөр өнгөрсөн нэг жилийн тайлангийн хугацаанд 2, 3 том төсөлрүү орж байгаа. 7 бүлэг 21 салбартай манай хөгжлийн хөтөлбөр гэж байгаа. Төсөл хөтөлбөр, үйл ажиллагааны стратеги гээд компанийн сайтан дээр ч байгаа гээд төсөл хөтөлбөрүүдийн талаар танилцуулга яриа хийж зарим хувьцаа эзэмшигчид тодруулга, асуулт асуув.

Хурлын дарга Ж.Жаргалсайхан: за сүүлийн асуудал буюу ТУЗ-ийн сонгуулийн тухай. Энэ асуудлыг хэн удирдаж явуулах билээ.

Гүйцэтгэх захирал Н.Алтансүх: Нэр дэвшүүлэх хороо. тэгэхээр та болноо гэсэн үг.

Хурлын дарга Ж.Жаргалсайхан ТУЗ-д нэр дэвшигчдийг нэг бүрчлэн танилцуулав. \Нэр дэвшигчдийн анкетийг хавсаргав\.

Хурлын дарга Ж.Жаргалсайхан: саналын хуудсуудаа тарааж өгөөд тооллогын комиссын дүн гартал 5 минут завсарлая.

Тооллогын комиссын дарга М.Отгонбаатар: За та бүхэндээ өнөөдрийн хурлаас гарсан тооллогын комиссын санал тоолсон дүнгийн тухай тогтоолыг уншиж танилцуулъя.

Тогтоолыг уншиж танилцуулаад Хувьцаа эзэмшигчдийн хурлын 04 тоот тогтоолыг батлахыг зөвшөөрөв.

Хурлын дарга Ж.Жаргалсайхан: Тооллогын комиссын дүн гарлаа гээд Тогтоолын төслийг уншиж танилцуулав.

Хурлын дарга Ж.Жаргалсайхан: Тогтоолын төслөө батлах уу?

Хувьцаа эзэмшигчид: Баталъя

Хурлын дарга Ж.Жаргалсайхан: за өнөөдрийн хурлаар хэлэлцэх ёстой асуудлаа хэлэлцэж дууслаа. Бүгдэд нь баярлалаа гэснээр 21:00 цагт өндөрлөв.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН

Б.ОТГОНЦАЦРАЛ

ХУРЛЫН ДАРГА

Ж.ЖАРГАЛСАЙХАН

